



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

“Тэнгри Секуритиес” ХХК-ийн  
брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Тэнгри секуритиес” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Тэнгри секуритиес” ХХК-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН